



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

2026 ОНЫ III УЛИРЛЫН ТАЙЛАН

Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын төсөөллийн нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2026

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2026 оны 8-р сарын 19-31-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 20 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Шинжээчид:

2026 оны III улиралд

- Инфляц бага зэрэг буурч 12.3%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.8%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.5%,
- Зээлийн хүү 17.6% байна гэж төсөөлсөн байна.

2027 оны II улиралд

- Инфляц буурч 9.7%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.3%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 12.1%,
- Зээлийн хүү өөрчлөлтгүй 17.6% байна төсөөлсөн байна.

Огноо	2026 он 7 сар	2026 он III улирал	2027 он II улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, %/	13.0%	12.3%	9.7%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	7.7%*	6.8%	6.3%
Төв банкны бодлогын хүү /%/	12.5%**	12.5%	12.1%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.4%	17.6%	17.6%


* 2026 оны эхний хагас

** 2026 оны 8 сарын 12-ны өдөр 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэв.

I. Инфляц


2026 оны 6-р сард улсын инфляц 12.0% гарсан нь өмнөх улирлын хүлээлт буюу 9.8%-аас 2.2 нэгж хувиар дээгүүр гарлаа. 2026 оны 7-р сард улсын инфляц 13.0% болж өссөн бөгөөд шинжээчид 2026 оны III улиралд улсын инфляц 12.3%, оны эцэст 11.4%, жилийн дараа 9.7% болж буурахаар хүлээж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын төсөөлөл




Шинжээчдийн инфляцын төсөөллийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны III улиралд инфляц 12.0-12.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.7%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны III улиралд инфляц 10.0-10.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 24.2% гэж төсөөлж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын төсөөллийн тархалт /2026 оны III улирал/




Энэ удаагийн инфляцын төсөөллийн үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад нэлээд өссөн боловч цаашид буурах хандлагатай байна. Шинжээчид 2026 оны III улирлын эцэст инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 9.5% гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.3% болно гэж үзжээ (Зураг 3).

Зураг 3. Инфляцын өмнөх төсөөллүүдийн харьцуулалт



Инфляцын төсөөллийг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу тус бүр 12.5, 12.1% байна (Зураг 4).


Зураг 4. Ирэх улирлын инфляцын төсөөлөл /2026 оны III улирал/



II. Эдийн засгийн өсөлт


2026 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт 7.7% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн төсөөллийн дундаж 6.7%-аас 1.0 нэгж хувиар өндөр гарчээ. Шинжээчид эдийн засгийн өсөлт 2026 оны эхний хагаст 6.8%, 2026 онд 6.6%, 2027 оны II улиралд 6.3% гэж төсөөлж байна (Зураг 5).

Зураг 5. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эдийн засгийн өсөлтийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны III улиралд 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.0%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны III улиралд өсөлт 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.1%, 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал 25.5% гэж төсөөлж байжээ (Зураг 6).

Зураг 6. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тархалт /2026 оны III улирал/




Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад бага зэрэг нэмэгдсэн хэдий ч цаашид одоогийн түвшнээс буурах хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2026 оны III улиралд эдийн засгийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 6.4% байна гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.8% гэж төсөөлжээ. Энэ удаагийн судалгаагаар 2026 оны жилийн өсөлтийг 6.6% байна гэсэн бол өмнөх судалгааны үр дүнгээр 2026 оны жилийн өсөлтийг 6.2% гэж үзэж байв (Зураг 7).

Зураг 7. Эдийн засгийн өсөлтийн өмнөх төсөөллүүдийн харьцуулалт



Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.6-6.9% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл /2026 оны III улирал/



III. Бодлогын хүү


Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2026 оны 8-р сарын 12-ны өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор шинжээчдийн бодлогын хүүний талаарх хүлээлт мөн нэмэгдсэн байна. Тухайлбал, шинжээчид бодлогын хүүг 2026 оны III улиралд дунджаар 12.5% орчимд хадгалагдана гэсэн хүлээлттэй байгаа бөгөөд 2026 оны эцэст бага зэрэг өсөж 12.7%-д хүрнэ гэж төсөөлжээ. Харин цаашид бодлогын хүү буурч, 2027 оны II улирлын эцэст 12.1% болох хүлээлттэй байна. (Зураг 9).

Зураг 9. Бодлогын хүүний хүлээлт




Бодлогын хүүний хүлээлтийг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2026 оны III улиралд бодлогын хүү 12.5% байна гэсэн хүлээлттэй байна (Зураг 10).

Зураг 10. Бодлогын хүүний хүлээлтийн тархалт /2026 оны III улирал, хариултын тоогоор/



Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны III улирлын бодлогын хүүг 12.0% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.5% байна гэж таамаглажээ (Зураг 11).


Зураг 11. Бодлогын хүүний өмнөх хүлээлтүүдийн харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2026 оны III улиралд дунджаар 17.6%, хамгийн ихдээ 18.0%, хамгийн багадаа 17.0%-тай байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид зээлийн хүү 17.5-17.6% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний хүлээлт




Зээлийн хүүний хүлээлтийг тархалтаар нь харвал 2026 оны III улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 17.4-17.6% байна гэсэн хүлээлт давамгайлж байна (Зураг 13).

Зураг 13. Зээлийн хүүний хүлээлтийн тархалт /2026 оны III улирал, хариултын тоогоор/



Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны III улиралд зээлийн хүүг 17.4% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 17.6% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

Зураг 14. Зээлийн хүүний өмнөх хүлээлтүүдийн харьцуулалт



--- o O o ---